

**ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ****2021 оны 12-р сарын 31-ний өдөр****№ЗГ20/69-3
№ЭТТ-2020/727-3****Улаанбаатар хот**

Энэхүү гэрээг 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн Зээлийн хорооны хурлын шийдвэр, 2021 оны 12-р сарын 30-ны өдрийн Зээлдэгчийн хүсэлтийг тус тус үндэслэн:

-Нэг талаас: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион Оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, ХААН Банк цамхаг хаягт орших, ХААН Банк ХХК буюу түүнийг төлөөлж Байгууллагын Банк хариуцсан Дэд захирал Т.Ууганбаяр, /цаашид "Банк" гэх/;

-Нөгөө талаас: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв хаягт орших, улсын бүртгэлийн 9010001097, регистрийн 5435528 дугаартай Эрдэнэс Таван Толгой ХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх Захирал албан тушаалтай, ФМ75081915 тоот регистрийн дугаартай, Монгол Улсын иргэн Борчууд ургийн овогт Баттулгын Ганхуяг, /цаашид "Зээлдэгч" гэх, гэрээнд оролцогчдыг хамтад нь "Талууд" гэх/ нар нь Монгол улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг үндэслэн талууд хүсэл зоригтоо чөлөөтэй илэрхийлж, энэхүү гэрээнд заасан нөхцөлийг харилцан зөвшөөрснөөр байгуулсан болно.

НЭГ.ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1. Талуудын хооронд байгуулсан 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн ЗГ20/69, ЭТТ-2020/727 тоот зээлийн гэрээгээр 230,000,000,000.00 /Хоёр зуун гучин тэрбум/ төгрөгийн зээлийг олгосон. Уг зээлийг зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн ЗГ20/69-1, ЭТТ-2020/727-1 тоот гэрээгээр ам.доллар руу хөрвүүлж 80,710,816.65 /Наян сая долоон зуун арван мянга найман зуун арван зургаан ам.доллар жаран таван цент/ ам.доллар болгосон бөгөөд тус зээлээс дараах төлбөрийг хийсэн байв.

-Үндсэн зээлд 57,927,884.15 ам. доллар;

-Зээлийн хүүгийн төлбөрт 7,860,328,767.12 төгрөг;

2,867,264.03 ам. доллар;

-Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт 0.00 ам. доллар;

1.2. Энэхүү гэрээг байгуулах өдрөөр зээлдэгч үндсэн зээлийн болох 22,782,932.50 /Хорин хоёр сая долоон зуун наян хоёр мянга есөн зуун гучин хоёр ам.доллар тавин цент/ ам.долларын зээлийн үлдэгдэлтэй байна.

1.3. Энэхүү гэрээг байгуулах өдрөөр зээлдэгчид өмнө олгосон зээлийн хуримтлагдсан хүүгийн үлдэгдэл 12,443.55 /Арван хоёр мянга дөрвөн зуун дөчин гурван ам.доллар тавин таван цент/ ам.доллар байгаа бөгөөд энэ хүүг Хавсралт 1 дэх "Эргэн төлөлтийн хуваарь"-ийн эхний төлбөр дээр төлөхөөр харилцан тохиролцов.

1.4. Зээлдэгчээс ирүүлсэн 2021 оны 12-р сарын 30-ны өдрийн №01/2829 тоот "Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа удааширсан тул зээлийн гэрээний хугацааг сунгуулах" албан хүсэлтийг үндэслэн талууд харилцан тохиролцож зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2.1. Талууд 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн ЗГ20/69, ЭТТ-2020/727 тоот зээлийн гэрээнд дараах өөрчлөлтийг оруулав. Үүнд:

2.1.1. Зээлийн гэрээний 2.1.9 дэх заалтыг "Зээлийн гэрээний хугацаа: 12 сарын хугацааг 2022 оны 05-р сарын 31-ний өдөр хүртэл 5 сараар сунгаж нийт 17 сар. Зээл анх олгосон өдрөөс эхлэн хугацааг тоолно." гэж өөрчлөх;

2.1.2. Зээлийн гэрээний 2.4.1 дэх заалтыг "Зээлийн энэхүү нэмэлт өөрчлөлтийн төлбөрийг Хавсралт 1-ээр шинэчлэн баталсан "Зээлийн эргэн төлөлтийн хуваарь"-ийн дагуу хуваарьт өдрийн 22.00 цагаас өмнө үл маргах журмаар эргүүлэн төлнө." гэж өөрчлөх;

2.2. Зээлийн гэрээний бусад зүйл заалтууд хэвээр дагаж мөрдөгдөх ба энэхүү гэрээ нь зээлийн гэрээний салшгүй хэсэг байна.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

3.1. 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн ЗГ20/69, ЭТТ-2020/727 тоот зээлийн гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээний зээл буцаан төлөх хуваарийн дагуу 2021 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл тооцогдож төлөгдсөн үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөр тооцоо маргаангүй болохыг үүгээр баталж байна.

3.2. 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн БГХ20/69, ЭТТ-2020/728 тоот Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт оруулах 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн БГХ20/69-1, ЭТТ-2020/728-01 тоот гэрээ, 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн БГХ20/69-2, ЭТТ-2020/728-2 тоот гэрээ нь хүчин төгөлдөр хэвээр үргэлжилж, Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн БГХ20/69-3, ЭТТ-2020/728-3 тоот гэрээний хамт энэхүү гэрээний үүргийг хангуулна.


3.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 5 эх хувь үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, талуудын аль нэг нь хүссэн тохиолдолд энэхүү гэрээг нотариатаар баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН:

БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ
Байгууллагын Банк хариуцсан Дэд захирал:

 /Т.Ууганбаяр/
(гарын үсэг)

Ахлах харилцааны менежер

 /С.Мөнхтулга/
(гарын үсэг)

Гэрээг бэлтгэсэн: Р.Алтан-Ундрах

ЗЭЭЛДЭГЧ
Эрдэнэс Таван Толгой ХК, түүнийг төлөөлж
Гүйцэтгэх Захирал:

 /Б.Ганхуяг/
(гарын үсэг)

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ
№01

ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

№	Огноо	Олгосон зээлийн үлдэгдэл дүн	Зээлийн эргэн төлөлт			
			Үндсэн зээлийн төлбөр	Зээлийн хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Зээлийн үлдэгдэл
	12/31/2021	22,782,932.50				22,782,932.50
1	01/28/2022		2,000,000.00	122,550.65	2,122,550.65	20,782,932.50
2	02/28/2022		2,000,000.00	111,202.92	2,111,202.92	18,782,932.50
3	03/28/2022		2,000,000.00	90,775.60	2,090,775.60	16,782,932.50
4	04/28/2022		2,000,000.00	89,800.18	2,089,800.18	14,782,932.50
5	05/28/2022		14,782,932.50	76,547.24	14,859,479.74	0.00
	Дүн	22,782,932.50	22,782,932.50	490,876.60	23,273,809.10	

ЗӨВШӨӨРСӨН:


БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ
Байгууллагын Банк хариуцсан Дэд захирал:

_____/Т.Ууганбаяр/

(гарын үсэг)

Ахлах харилцааны менежер

_____/С.Мөнхтулга/

(гарын үсэг)

Гэрээг бэлтгэсэн: Р.Алтан-Ундрах



ЗЭЭЛДЭГЧ
Эрдэнэс Таван Толгой ХК, түүнийг төлөөлж
Гүйцэтгэх Захирал:

_____/Б.Ганхуяг/

(гарын үсэг)



**БАРЬЦААНЫ ГЭРЭЭНД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ**
(Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө)

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

**№БГХ20/69-3
№ЭТТ-2020/728-3**

Улаанбаатар хот

ЭНЭХҮҮ БАРЬЦААНЫ ГЭРЭЭ-г

-Нэг талаас: регистрийн 2693321 дугаар, улсын бүртгэлийн 9016001011 дугаар бүхий Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион Оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, ХААН Банк цамхаг хаягт орших, ХААН Банк ХХК буюу түүнийг төлөөлж Байгууллагын Банк хариуцсан Дэд захирал Т.Ууганбаяр, /цаашид “Барьцаалагч” гэх/;
-Нөгөө талаас: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв хаягт орших, улсын бүртгэлийн 9010001097, регистрийн 5435528 дугаартай Эрдэнэс Таван Толгой ХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх Захирал албан тушаалтай, ФМ75081915 тоот регистрийн дугаартай, Монгол Улсын иргэн Борчууд ургийн овогт Баттулгын Ганхуяг, /Цаашид Барьцаалуулагч” гэх/, (гэрээнд оролцогчдыг хамтад нь “Талууд” гэх) нар нь Монгол улсын Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хууль, журмыг үндэслэн талууд хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлж, энэхүү гэрээнд заасан нөхцөлийг харилцан зөвшөөрснөөс байгуулсан болно.

НЭГ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

- 1.1. 2020 оны 12-р сарын 31-ны өдрийн БГХ20/69, ЭТТ-2020/728 тоот Барьцааны гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг талууд харилцан тохиролцож оруулав. Үүнд:
- 1.1.1 Барьцааны гэрээний 1.1 дэх заалтыг “Энэхүү гэрээгээр Банк, Зээлдэгчийн хооронд 2020 оны 12-р сарын 30-ны өдөр байгуулсан ЗГ20/69, ЭТТ-2020/727 тоот зээлийн гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн ЗГ20/69-1, ЭТТ-2020/727-1 тоот гэрээ, 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн ЗГ20/69-2, ЭТТ-2020/727-02 тоот гэрээ, 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн ЗГ20/69-3, ЭТТ-2020/727-3 тоот гэрээний (Цаашид “Зээлийн гэрээ” гэх) үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалуулагчийн хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг барьцаалах, барьцааны баталгаажилт хийх, барьцааны эрх хэрэгжүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.” гэж өөрчлөх;
- 1.1.2 Барьцааны гэрээний 1.2 дахь заалтыг “ХААН банк ХХК болон зээлдэгч Эрдэнэс Таван Толгой ХК нарын хооронд 2020 оны 12-р сарын 30-ны өдөр байгуулсан ЗГ20/69, ЭТТ-2020/727 тоот зээлийн гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн ЗГ20/69-1, ЭТТ-2020/727-1 тоот гэрээ, 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн ЗГ20/69-2, ЭТТ-2020/727-02 тоот гэрээ, 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн ЗГ20/69-3, ЭТТ-2020/727-3 тоот гэрээ нь /цаашид зээлийн гэрээ гэх/, барьцаалагчийн барьцааны эрхийг олж авах үндэслэл болсон болно. Уг гэрээний гол нөхцөлүүд:” гэж өөрчлөх;
- 1.1.3 Барьцааны гэрээний 1.2.3 дахь заалтыг “Үүрэг гүйцэтгэх хугацаа: ХААН банк ХХК болон зээлдэгч Эрдэнэс Таван Толгой ХК нарын хооронд 2020 оны 12-р сарын 30-ны өдөр байгуулсан ЗГ20/69, ЭТТ-2020/727 тоот зээлийн гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн ЗГ20/69-1, ЭТТ-2020/727-1 тоот гэрээ, 2021 оны 07-р сарын 26-ны өдрийн ЗГ20/69-2, ЭТТ-2020/727-02 тоот гэрээ, 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн ЗГ20/69-3, ЭТТ-2020/727-3 тоот гэрээнд зааснаар тодорхойлогдоно.” гэж өөрчлөх;
- 1.1.4 Барьцааны гэрээний 2.7 дахь заалтыг “Барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх, төлбөр гүйцэтгэх хугацаа давтамж, түүнийг тодорхойлох: Барьцаагаар хангагдах үүрэг болон түүнийг хэсэгчлэн гүйцэтгэхийг гэрээний 1.1, 1.2-т заасан Зээлийн гэрээ түүний Хавсралт “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-т заасан хугацаа, хэмжээгээр гүйцэтгэх бөгөөд энэ нь Зээлийн гэрээнд зааснаар тодорхойлогдоно.” гэж өөрчлөх;
- 1.2. Барьцааны гэрээний бусад зүйл заалтуудад өөрчлөлт ороогүй бөгөөд талууд хэвээр дагаж мөрдөнө.

ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

- 2.1 Энэ гэрээг Монгол хэл дээр 5 хх хувь үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, талуудын аль нэг нь хүссэн тохиолдолд энэхүү гэрээг нотариатаар баталгаажуулснаар энэ гэрээ хүчин төгөлдөр болно.
- 2.2 Энэ гэрээ нь Зээлийн гэрээ, барьцааны гэрээний салшгүй хэсэг болно.

БАРЬЦААНЫ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БАЙГУУЛСАН:



БАРЬЦААЛАГЧ:
Байгууллагын Банк хариуцсан Дэд захирал:

Т.Ууганбаяр/



БАРЬЦААЛУУЛАГЧ:
Эрдэнэс Таван Толгой ХК, түүнийг төлөөлж
Гүйцэтгэх Захирал:

Б.Ганхуяг/



ХААН БАНК

Ахлах харилцааны менежер


_____/С.Мөнхтулга/
(гарын үсэг)

Гэрээг бэлтгэсэн: Р.Алтан-Ундрах

